Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд 2022 оны 07 сарын 04-ны өдрийн 5891 дугаарт бүртгэв.

# БАЯНХОНГОР АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2022 оны 06 сарын 17 өдөр Дугаар 7/14 Эмээлтолгой

Хог хаягдлын үйлчилгээний хураамж, үнэ тариф тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.15, 35 дугаар зүйлийн 35.1.10, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1, 9.2.2 дахь заалтыг үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Сумын нутаг дэвсгэрт мөрдөх энгийн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх үнэ тарифыг нэгдүгээр хавсралтаар, хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг хоёрдугаар хавсралтаар тус тус батлсугай.

2.Хог хаягдлын үйлчилгээний хураамж, үнэ тарифыг аж ахуйн нэгж, албан байгууллага, айл өрхүүдэд мөрдүүлж, тогтоолын хэрэгжилтийг жил бүр Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж ажиллахыг сумын Засаг дарга (Д.Мөнхжаргал)-д үүрэг болгосугай.

3.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн 15/02 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4.Тогтоолыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхийг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Д.Уранчимэг)-д даалгасугай.

ДАРГА П.БАЯРСАЙХАН

дугаар 27
БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЖАРГАЛАНТ СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ
ХУУЛБАР ҮНЭН
Хуулбар олгосон ажилтны гарын үсэг
2022 оны 06 сарын 23 ний өдөр
1519024

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны
06 дугаар сарын 17-ны өдрийн ээлжит VII хуралдааны
7/14 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт

# ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫГ ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ ҮНЭ ТАРИФ

| № | Нэр төрөл | Хэмжих нэгж | Үнэ /төг/ |
|---|---|---|---|
| 1 | Поошик хог | Төмөр поошик /200 л/ | 3000 |
| 2 | 1 шуудай хог | 50 кг | 1000 |
| 3 | 1 тонн хог | 1тн | 20000 |

_________∞_________

Бүртгэлийн дугаар 07
БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЖАРГАЛАНТ СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ
ХУУЛБАР ҮНЭН
Хуулбар олгосон ажилтны гарын үсэг
2022 оны 06 сарын 23-ний өдөр

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны
06 дугаар сарын 17-ны өдрийн ээлжит VII хуралдааны
7/14 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралт

## ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖ

| д/д | Хог хаягдал гаргагч эх үүсвэр | | Хэмжих нэгж | Үйлчилгээний хураамж | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Жилд | Сард |
| 1 | Айл өрх | | 1 иргэн | 1000 | |
| 2 | Албан байгууллага | ЗДТГ | Орон тоо | | 2574 |
| 3 | | Хүн эмнэлэг | Ор хоног | | 7789 |
| 4 | | ЕБСургууль | Сурагчдын тоо | | 25677 |
| 5 | | Цэцэрлэг | Хүүхдийн тоо | | 11484 |
| 6 | | Соёлын төв | Суудлын тоо | | 2105 |
| 7 | | Банк | 1 ажилтан | | 2500 |
| 8 | Худалдаа үйлчилгээ | Хүнсний дэлгүүр | 50 м/кв дээш | | 9125 |
| 9 | | Хүнсний дэлгүүр | 50 м/кв доош | | 4625 |
| 10 | | Эмийн сан | 1 ажилтан | | 3500 |
| 11 | | Зочид буудал | 1 ор | | 2000 |
| 12 | | ШТСтанцууд | $М^2$ | | 2000 |
| 13 | | Цайны газар | 1 ажилтан | | 4000 |
| 14 | | Үсчин | 1 ажилтан | | 3500 |
| 15 | | Дугуй засвар | 1 ажилтан | | 3500 |

———∞———

Бүртгэлийн дугаар 27
БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЖАРГАЛАНТ СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ
ХУУЛБАР ҮНЭН
Хуулбар олгосон ажилтны гарын үсэг
2022 оны 06 сарын 23 ний өдөр